

## “ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЛИЙН ТҮҮВЭР” НОМЫН ТУХАЙ

*Э.Гансүх\**

Монгол Улсын ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэн болон Хятадын Өвөр Монголын Зүүн Хойт Ази Судлалын Хүрээлэнгийн хооронд эрдэм шинжилгээний харилцаа байгуулаад даруй 10 гаруй жил болжээ. Энэ хугацаанд дээрхи хоёр байгууллага эрдэмтэн судлаачдаа солилцож, эрдэм шинжилгээний хурал зөвлөлгөөн тогтмол хийж ирсний сацуу эрдэмтдийн бүтээлийг харилцан нийтэлж, хэд хэдэн ном хамтран хэвлүүлжээ. Үүний нэг болох уншигч таны өмнө толилуулж буй “Эрдэм шинжилгээний өгүүллийн түүвэр” хэмээх хамтын бүтээлийг хятад, монгол хэлээр орчуулан 2004 онд Хөх хотноо хэвлэсэн бөлгөө.

“Эрдэм шинжилгээний өгүүллийн түүвэр” хэмээх энэхүү хамтын бүтээлд дээрхи эрдэм шинжилгээний хоёр хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын 12 өгүүлэл багтжээ. Эрдэм шинжилгээ судалгааны өгүүлүүдийн товч агуулга нь Монгол Улс ба Зүүн Хойт Азийн улсуудын хооронд аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж, хөгжлийн ази “загвар” гэж юу болох, уул уурхайн салбар дахь Монгол-Хятадын харилцаа: өнөөгийн байдал хэтийн төлөв, БНХАУ-ын баруун бүс нутгийг хөгжүүлэх бодлого стратеги энэ нь манай хөгжилд нөлөөлөх боломж, худалдааны чөлөөт бүс, Монгол – Хятадын хамтарсан жижиг дунд үйлдвэрийн өнөөгийн байдал хэтийн төлөв, хилийн худалдаа түүний ач холбогдол, өнөөгийн байдал, Монгол Улс ӨМӨЗО-ны соёлын харилцааны хөгжил, түүх зэрэг сэдвээс бүрдэж байна.

Уг хамтын бүтээлд орсон эрдэм шинжилгээний өгүүлүүдийг тус тусад нь авч үзвэл, ӨМӨЗО-ны Зүүн Хойт Ази Судлалын Хүрээлэнгийн судлаач Насангийн бичсэн “Монгол Улс болон ЗХА-ийн улсуудын хооронд аялал жуулчлал хөгжүүлэх хэтийн төлөв” хэмээх өгүүллээр эхэлжээ. Тэрбээр ЗХА-ийн улсууд болон Монгол Улс хамтран аялал жуулчлал хөгжүүлэх тухай өөрийн үзэл бодлоо бичихдээ: “Монгол Улс XXI зууны хөгжлийн хөтөлбөртөө аялал жуулчлалыг хөгжүүлэхээр заажээ. Монгол Улс байгалийн болон хүмүүнлэгийн аялал жуулчлалын арвин баялагтай тул аялал жуулчлалыг хөгжүүлэх давуу тал маш их. Гэвч Монгол Улсын хүн ам цөөн, аялал жуулчлалын зах зээлийг хөгжүүлэхэд нэлээд хязгаарлагдмал шинжтэй, ялангуяа Монгол Улс өнөөдөр эдийн засгаа сэргээн хөгжүүлэх шатандаа явж байгаа тул хөрөнгө мөнгөний дутагдалтай гэх мэт хүчин зүйл нь Монголын аялал жуулчлалын хөгжлийг түргэтгэхэд ноцтой саад болж байна гээд цааш нь энэ байдлаас гарах хамгийн сайн аргын нэг нь гадаадын хөрөнгө оруулалтыг Монголд их

\*Э.Гансүх - МУИС-ийн ГХСС-ийн Хятад судлалын 4-р дамжааны оюутан

хэмжээгээр татах явдал юм” гэжээ. Судлаач өгүүллийнхээ ЗХА-ийн бүс нутагт аялал жуулчлалын хөгжлийг түргэтгэх тухай хэдэн санал тавьж: Монгол Улс аялал жуулчлалыг цаашид хөгжүүлэхдээ анхаарч баримтлах 5 зүйлийг тоочсон байна. Тухайлбал, 5-р зүйлд: “... ЗХА-ийн улсууд, ялангуяа эдийн засгийн хүчин чадал ихтэй Япон, БНСУ зэрэг улс Хятадын Рашаанаас Монголын Чойбалсан хүрэх төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд Монголд хэрэгжүүлэх төсөл болгож болох агаад хэрэв уг замыг түргэн нэвтрүүлбэл мянган үеэр дурсагдах агуу гавьяа болох нь дамжиггүй юм” (т.10) гэснээс үзэхэд уг төмөр зам манай улсад ямар их ач холбогдолтойг харуулж байгаа болов уу.

Номын дараагийн өгүүлэл Монгол Улсын ШУА-ийн ОУСХ-ийн эрдэмтэн доктор (Sc.D), профессор П.Хайсандайн “Хөгжлийн ази “загвар” бол бүс нутгийн хамтын ажиллагааны чухал хөшүүрэг мөн” гэсэн өгүүлэл болно. Судлаач өгүүллийнхээ эхэнд хөгжлийн ази “загвар” гэж юу болох, ямар давуу талтайг эдийн засаг нь өндөр хөгжиж яваа Япон, Солонгос, Хятад, Малайз, Сингапур . . . гэх мэт орны жишээн дээр тайлбарлаж эдийн засгийнх нь хөгжилд нөлөөлсөн 3 хүчин зүйлийг дурьдсан байна. Үүнд: “1-рт: эдийн засгийн цаашдын хөгжилд чухал ач холбогдолтой тэргүүний технологийг гадаадаас импортлох замаар нэвтрүүлсэн. 2-рт: хөгжлийн Англи-Саксон загвараас ялгаатай нь эдгээр улс орны хөгжилд төрийн зохицуулалт чухал ач холбогдолтой байсан явдал. 3-рт: “Энэ бүс нутгийн ард түмэн бол их хөдөлмөрч хүмүүс...” гээд “Манай улс жижиг, ядуу буурай орон болохоор шилжилтийн арга зам нь экспортын чиг баримжааг эрхэмлэдэг, гадаадын хөрөнгө оруулалтанд илүү найдаж, төлбөрийн балансыг нэг их чухалчилдаггүй болохоор Солонгос мэтийн жижиг орны загвартай төстэй” гэжээ. Судлаач өгүүлэлдээ бас Монгол Улс хөгжлийнхөө загварт баримтлах зарчмыг 4 зүйлээр тодорхой гаргаж өгчээ. Тухайлбал, 1-р зүйлд: “... жижиг орны хувьд Монгол Улс Солонгос, Тайванийн нэгэн адил гадагш чиглэсэн экспортонд баримжаатай өсөлтийн хэв загварыг авч хэрэглэвэл зохистой” гэсэн байна.

Монголын эдийн засгийг хөгжүүлэхэд тэргүүлэх ач холбогдолтой байдаг уул уурхайн салбарын талаар “Уул уурхайн салбар дахь Монгол-Хятадын харилцаа: өнөөгийн байдал, хэтийн төлөв” нэртэй өгүүллийг Монгол Улсын ШУА-ийн ОУСХ-ийн эрдэмтэн Д.Шүрхүү доктор (Ph.D) бичсэн байна. Судлаач өгүүллийнхээ эхний хэсэгт Монголын уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж, гадаадын хөрөнгө оруулалт ихээр орж ирж, гадаадын хөрөнгө оруулагчдад хууль эрх зүйн таатай орчин бүрдэж байгаа талаар бичээд, ашигт малтмалын төрөл тус бүрээр тодорхой авч үзжээ. Судлаач өгүүллийнхээ дүгнэлтийн хэсэгтээ Монголын уул

уурхайн салбарыг төсөөлөхдөө: “Хоёр хөршийнхөө сар, жил тутам тасралтгүй өргөжин тэлж, улам бүр нээлттэй болсоор түлш, эрчим хүч, ашигт малтмалын зах зээлийн аль болох бүрэн дүүрэн ашиглаж чадвал богино хугацаанд эдийн засгаа хөл дээрээ босгон, ард түмнийхээ аж байдлыг эрс өөрчлөн сайжруулах түүхэн нөхцөл бололцоо бүрдэж байгааг дээр өгүүлсэн жишээ баримтууд ямар нэг хэмжээгээр нотлон харуулж байна” гэсэн байна. Дашрамд дурьдахад, Монголын уул уурхайн салбарын талаархи хууль тогтоомж либерал шинжтэй, лицензийн эрх уян хатан бодлоготой байдаг хэмээн гадаадын томоохон олон пүүс компани үнэлдэг ажээ.

Монгол Улсын ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D) К.Дэмбэрэл “Төв Азийн геостратегийн асуудлууд ба Монгол Улс” нэртэй өгүүлэлдээ Төв Азийн геостратегийн бүтцийг Төв Ази дахь хүчний харьяаг тус тус тодорхойлохыг зорьж, Төв Азид гарч болох стратегийн түншлэлүүд тэдгээрийн оршин тогтнох багтаамжийн талаар бичжээ. Тэрбээр Монгол Улсын геостратегийн ирээдүйн төлвийг тодорхойлохдоо: “Төв Азид глобал ба бүс нутгийн хэмжээний “тоглогчдын” сонирхол зэрэгцэн оршин буйг анхааран Монгол Улсын эрх ашигт нийцүүлэн өөрийн хөгжлийн стратегид тусгах нь чухал.

Төв Азид Орос-Иран-Хятадын түншлэл бий болсон тохиолдолд Монгол Улс хүссэн хүсээгүй татагдан орно. Бүс нутгийн глобал гүрнүүд Төв Азид сонирхлоо нэмэгдүүлэхийн тулд уг бүс нутаг дахь “хүндийн хүч”-ийг голлон сонирхох нь дамжиггүй” гэсэн дүгнэлт хийжээ.

“Баруун бүсийн хөгжил хийгээд Хятад-Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа” гэсэн сэдвээр ӨМӨЗО-ны ЗХАСХ-ийн судлаач Насан, Мэн Липэн нар бичжээ.

Энэхүү өгүүлэлд Хятадын баруун бүс нутгийг хөгжүүлэх болон Хятад-Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаанд үзүүлэх нөлөө, Хятад-Монголын эдийн засаг худалдааны хамтын ажиллагааг түргэн хөгжүүлэх зэрэг асуудлыг хөндсөн байна. Хятадын баруун бүсийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө нь Монгол Улсын хөгжил, дэвшил, Хятад-Монголын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаанд нөлөөлж болох 5 зүйлийг дурьдсан байна. Үүнд: “1-рт: Баруун бүсийг хөгжүүлэх стратеги, зорилт нь Хятадын баруун бүсийн, эдийн засгийн хөгжлийг түргэтгэж, зүүн баруун бүсийн хоорондын зөрүүг багасгаж, Хятадын эдийн засгийг тэнцвэртэй хөгжүүлэх явдал юм... Иймээс Хятадын бүсийн хөгжил, тогтвортой байдал нь Монгол Улсын хөгжилд таатай гадаад орчин бүрдүүлж, Монгол Улсын эдийн засгийн хөгжилд ихээхэн түлхэц өгөх болно” гэжээ. Судлаачид мөн Хятад-Монгол хоёр улс боломжийг ашиглан эдийн засаг худалдааны хамтын ажиллагаагаа түргэтгэвэл зохих 5 салбар, чиглэлийг тодорхойлсон байна. Тухайлбал: нэгдүгээрт,

Хятад-Монгол хоёр орон худалдааны чөлөөт бүсийн бүтээн байгуулалтаа эрчимжүүлэх; хоёрдугаарт, Хятад-Монгол хоёр улс дэд бүтцийн бүтээн байгуулалтын хүрээн дэх хамтын ажиллагаагаа эрчимжүүлбэл зохино. Гуравдугаарт, Хятад-Монгол хоёр улс ашигт малтмалаа олборлох давуу талаа харилцан нөхөх; дөрөвдүгээрт, хоёр тал худалдааны хамтын ажиллагаагаа бүх талаар эрчимжүүлэх; тавдугаарт, Хятад-Монголын аялал жуулчлалын хамтын ажиллагааны хэтийн төлөв гэсэн 5 салбар чиглэлийг дурьдсан байна.

“Монгол Улс, Өвөрмонголын ард түмний соёлын харилцааны түүхээс” гэсэн өгүүллийг Монгол Улсын ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D) Ч.Батцэцэг бичжээ. Өгүүлэлдээ хоёр орны ард түмний соёлын харилцааны түүх, хөгжлийг мэдээ баримтанд тулгуурлан гаргасан байна. Монгол Улс, Өвөрмонголын хооронд эртнээс соёлын харилцааны түүхэн уламжлалтай бөгөөд хоёр орны соёлын харилцаа тасралтгүй үргэлжилж, соёлын хувьсгалын үеийг эс тооцвол хоёр орны харилцаа улам бүр хөгжсөөр, Монгол Улс соёлын хөрөнгө оруулалт хийж буйг онцлон тэмдэглэжээ.

ӨМӨЗО-ны ЗХАСХ-ийн судлаач Хаварцэцэгийн бичсэн “МАХН 4 жил эрх барьсан хугацаанд Монгол Улсын нийгэм эдийн засгийн байдал” гэсэн сэдэвтэй өгүүлэл бөлгөө. Тус өгүүлэлд судлаач МАХН 4 жилийн хугацаанд эрх барихдаа хийж бүтээсэн ажлыг үнэлж, өөрийн дүгнэлтийг хийсэн байна. Үүнд: Нэгд. Эдийн засаг тогтвортой өсөв. Хоёрт, Гадаад худалдааны харилцаа болон түүний хөгжил. Гуравт. Банк санхүүгийн бодлогыг дорвитой хэрэгжүүлэв. Дөрөвт. Дэд бүтцийн бүтээн байгуулалтыг идэвхтэй ахиулжээ. Тавд. Цалингийн хамгийн доод хэмжээг хэдэн хувиар өсгөв. Зургаад. Иргэдийн боловсрол, эрүүл мэндэд ихээр анхаарав хэмээн 6 зүйлээр задлаж бичсэн байна. Судлаач өгүүлээ 2000 оноос өмнөх Засгийн газрын үйл ажиллагаатай холбож, харьцуулан бичжээ.

ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D) Н.Ариунгуагийн бичсэн “БНХАУ-ын баруун бүс нутгийг эрчимтэй хөгжүүлэх бодлого ба ӨМӨЗО-ны мал аж ахуйн бүс нутгийн хөгжлийн төлөв” өгүүлэлдээ дээрхи бодлогын ач холбогдолтой талыг дурьдахдаа: “Баруун бүс нутгийг хөгжүүлэх бодлогын хүрээнд ӨМӨЗО зэрэг мал аж ахуйн бүс нутгуудын эдийн засаг, байгаль орчин, нийгмийн хангамжийн асуудлыг шийдвэрлэн мал аж ахуйн бүс нутгийн хөгжлийн цоо шинэ загварыг бий болгох ажээ. Энэхүү бодлого хэрэгжсэнээр монгол зэрэг нүүдэлчин цөөнх үндэстний амьдралын хэв маяг, уламжлалт соёл, зан заншил, ... экологийн аюулгүй байдлыг хангах, өнөө ба ирээдүйд суурьшсан монгол үндэстний хүн ам, амьжиргааны асуудал зэрэг үндэстний бодлоготой холбоотой асуудлыг хэрхэн зүй зохистой шийдвэрлэхээс энэ бодлогын амжилт мөн шалтгаалах юм” гэсэн байна.

ӨМӨЗО-ны ЗХАСХ-ийн судлаач Баатар “Хятад, Монголын хилийн худалдааны чөлөөт бүс байгуулах тухайд” гэсэн өгүүлэлдээ: Хятад-Монголын хилийн худалдааны чөлөөт бүс байгуулах боломжийг 6 зүйлд багтаан бичжээ. Уг “Эрдэм шинжилгээний өгүүллийн түүвэр” номонд чөлөөт бүсийг байгуулах асуудлаар хоёр өгүүлэл оржээ. Өгүүлэл тус бүрт ерөнхий агуулга адилхан, хамгийн гол нь энэ чөлөөт бүсийн ажлыг яаралтай эхлэх нь юу юунаас илүүг чухалчилсан байна.

Мөн ОУСХ-ийн ажилтан доктор (Ph.D) Ариунгуа “Монгол-Хятадын хамтарсан жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн газруудын үйл ажиллагаа, хэтийн төлөв” нэртэй өгүүлэл бичжээ. Түүнд жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх нь улс орны эдийн засгийн хөгжлийг түргэтгэх бас нэгэн хүчин зүйл мөнөөс мөн билээ. Манай орон ядуу буурай аливаа зүйлийг эрхэлж, хөгжүүлэе гэхээр хөрөнгө мөнгөний дутагдал их болохоор гадаадын хөрөнгө оруулалтыг татах нь чухал юм гэдгийг тодорхой гаргажээ. Судлаач жижиг дунд үйлдвэрийн талаар АНУ, ОХУ-ын баримталдаг бодлогыг жишээ болгож бичээд, цааш нь “Зах зээлийн эдийн засагт шилжиж байгаа манай улсын хувьд ч гэсэн жижиг дунд үйлдвэр, аж ахуйн газруудыг хөхиүлэн дэмжих нь маш чухал бөгөөд энэ нь үндэсний үйлдвэрийг сэргээх, нөгөөтэйгүүр Монголын нийгэмд хурцаар тавигдаж буй ажилгүйдлийн асуудлыг шийдвэрлэхэд маш том хөшүүрэг болох юм” гээд “хэдийгээр Монголд Хятадын хөрөнгө оруулалттай болон хамтарсан жижиг дунд үйлдвэр аж ахуйн газар 500 орчим байдаг, Хятадын шууд хөрөнгө оруулалт Монгол Улсад тэргүүн байр эзэлдэг боловч манай улсын эдийн засагт гадаад секторын хувьд Хятад улсын хөрөнгө оруулалт, оролцоо нь далайцын хувьд хангалттай биш. Хятадын хөрөнгө оруулалттай үйлдвэр, аж ахуйн газрууд дахь монголчуудын хөдөлмөр эрхлэлт ч их биш байна. Мөн эдгээр үйлдвэрүүдээр дамжин тэргүүний техник технологи орж ирэх нь тун хэцүү юм” гэж Хятадын хөрөнгө оруулалттай жижиг дунд үйлдвэрийн дутагдалтай талыг шүүмжлэн бичсэн байна. Тэгээд эдгээр үйлдвэрийн үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд Монголд ажиллах боломжийг илүү нээлттэй болгох нь зүйтэй гэж үзсэн байна.

Аливаа юм сайн муу хоёр талтай, ач холбогдолтой байдаг. Судлаач эдгээр үйлдвэрийн Монголд үзүүлж буй үр ашгийн талаар бичихдээ: “Эдгээр жижиг дунд үйлдвэрлэл нь манай хүн амын хэрэгцээг хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тодорхой хэмжээний хувь нэмэр оруулж байгааг үгүйсгэж болохгүй. Юуны түрүүнд хүн амын хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг шийдэхэд хөшүүрэг болж байгаагаас гадна манай улс шиг зах зээлийн жижиг багтаамжтай, том хэмжээний үйлдвэрлэл явуулахад бэрхшээлтэй эдийн засагтай оронд жижиг дунд үйлдвэрийн эхлэлийг тавьж өгч байгаагаараа онцлог юм” гэсэн байна.

Үүнээс үзэхэд гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд төрөөс хөрөнгө оруулалтын тухай хуульд уян хатан бодлого баримталж, татварын хөнгөлөлт, зах зээлээ судлах гэх мэт олон асуудал нээлттэй болох нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D) Ч.Батцэцэг “Монгол-Хятадын хил орчмын бүс нутгийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа” сэдвээр бичсэн өгүүлэлдээ, хилийн худалдааны талаар онцолж, Монгол-Хятадын хил орчмын бүс нутгийн худалдааны түүх, одоогийн байдал, хэтийн төлөв, хилийн худалдаанд тулгамдаж буй асуудлыг хөндөж, нөхцөл байдлыг тодорхой гаргахыг зорьжээ. Тэрбээр хилийн худалдааны ач холбогдлын талаар бичихдээ: “Хилийн худалдааны цар хүрээ ихээс гадна гадаад эдийн засгийн худалдааны хамтын ажиллагааны харьцангуй чухал бүрэлдэхүүн хэсэг болдог. Хилийн худалдааны хөгжил нь бүс нутгийн, олон улс хоорондын эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааг бэхжүүлдэг учир харьцангуй олон улсын шинж чанартай юм” гэжээ.

Нөгөөтэйгүүр Монгол-Хятадын хил орчмын худалдаа аажмаар тэлэхийн сацуу хилийн худалдаа хийх явцад хоёр талын аж ахуйн нэгжүүдийн хооронд гардаг элдэв бэрхшээл, дутагдал, зөрчлийг тодорхой гаргаж тавьсныг холбогдох байгууллагууд болон хувь хүмүүс анхааралдаа авч Хятадын талтай хийх гэрээ хэлэлцээрээ боловсронгуй болгохыг сануулж байгаа болов уу.

Мөн судлаач Эрээн, Замын-Үүдийн боомтыг ашиглан Худалдааны чөлөөт бүс байгуулах нөхцөл нэгэнт төлөвшиж байгаа талаар бичсэн байна.

Номын төгсгөлд доктор Л.Бэгзжавын “Монгол-Хятадын эдийн засгийн интеграцийн хэтийн төлөв” нэртэй өгүүлэл оржээ. Судлаач тус өгүүлэлдээ Улаанбаатар хотыг Худалдааны чөлөөт бүс болгох саналтай байгаагаа илэрхийлжээ.

Монгол Улс, Өвөр Монголын эрдэмтдийн хамтран гаргасан энэхүү ном нь Монгол-Хятад хоёр орны олон талын хамтын ажиллагааны талаар бичсэн судалгааны чамбай бүтээл болжээ. Уг бүтээлийг уншсанаар Монгол Улс эдийн засгаа хөгжүүлж байгаа өнөө үед манай төр засгийн тэргүүн болон бодлого боловсруулагчид эрдэмтэн судлаачидтай хамтран ажиллавал илүү үр өгөөжтэй байх болов уу гэсэн сэтгэгдэл төрөв.